УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2020 оны 09 сарын 30 өдөр Дугаар А/287 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийгдэх зарим төсөл, арга хэмжээ, зарцуулах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх ажлыг гүйцэтгэхээр шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулж, ажлын явц, биелэлтийг тайлагнаж ажиллахыг Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс /М.Гансэлэм/-т даалгасугай.

3. Дээрх төсөл, арга хэмжээнүүдэд зарцуулах нийт 163.750.000 /Нэг зуун жаран гурван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийг Ногоон байгууламжийн арчилгааны зардлаас санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

c:\users\gantuya\desktop\уж 12\doc 2020\тушаал 3doc.docx

1110300924

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 09 дүгээр сарын 30 ны
өдрийн 1227 тушаалын хавсралт

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АРЧИЛГААНЫ
ЗАРДЛААС САНХҮҮЖИХ ЗАРИМ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Зарцуулах зардал /төгрөг/
1	Гудамж, талбайд байршуулах 1000 ширхэг саванд тарих гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац худалдан авах ажил. Үүнд:				
	Монос /1,2-1,5м өндөртэй/	ширхэг	5000	10000	50.000.000
	Голт бор /1,0-1,2м өндөртэй/	ширхэг	5000	5000	25.000.000
	Тэхийн шээг /0,5-0,7м өндөртэй/	ширхэг	1665	6000	10.000.000
2	Мод, сөөг тарих ажилд хэрэглэгдэх хар шороо худалдан авах ажил	м3	500	350000	8.750.000
3	Сав /торх/-нд гоёл чимэглэлийн мод сөөг тарих, арчлах ажил	ширхэг	1000 саванд	70000	70.000.000
	ДҮН /төгрөг/				**163.750.000**